



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.1, 28.1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх түр журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Г.Мөнхсайхан/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /А.Ариунзаяа/, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт тус тус даалгаж, Монголын улаан загалмай нийгэмлэг, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагад зөвлөсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын орлогч дарга /бригадын генерал Г.Ариунбуян/-д даалгасугай.

ДАРГА


Г.СОДБААТАР
Г.СОДБААТАР

Улсын Онцгой комиссын даргын 2020
оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
#5 дугаар тушаалын хавсралт

**ЗОРИЛТОТ БҮЛЭГ, ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД БАЙГАА ИРГЭН, ӨРХӨД
ХҮНС, ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ТҮГЭЭХ,
ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ДЭГЛЭМ МӨРДӨХ ТҮР ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх үед дараах зарчмыг баримтална:

- 1.1.1. Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, халдвараас сэргийлэх;
- 1.1.2. Ил тод, хариуцлагатай байх;
- 1.1.3. Ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх;
- 1.1.4. Хүнс, тэжээлийн дэмжлэг хүртээмжтэй байх;
- 1.1.5. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулах.

1.3. Хүнс, тэжээлийн дэмжлэгийн бараа, бүтээгдэхүүний үнийг тухайн орон нутгийн зах зээлийн үнээс хэтрүүлэхгүй.

1.4. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэхэд Эрүүл мэндийн болон мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, заавар, журам болон энэ журмыг хэрэгжүүлнэ.

1.5. Олон улсын хүмүүнлэгийн байгууллагын тусламжаар үзүүлэх хүнс, тэжээлийн дэмжлэгийг энэ журмаар зохицуулж болно.

**Хоёр. Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай зорилтот бүлэг,
эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхийг тодорхойлох**

2.1. Хүнс, тэжээлийн дэмжлэг шаардлагатай хүн амын зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхийг тодорхойлох шалгуурыг дараах үндэслэл, шаардлагыг харгалзан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас батална.

- 2.1.1. Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт заасны дагуу тодорхойлсон эмзэг бүлэгт хамаарах иргэн, өрх;
- 2.1.2. Харгалзагч, асран хамгаалагчгүй ахмад настан;
- 2.1.3. Харгалзагч, асран хамгаалагчгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн;
- 2.1.4. Харгалзагч, асран хамгаалагчгүй хүүхэд;
- 2.1.5. 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх;
- 2.1.6. Өрх толгойлсон эцэг, эх;
- 2.1.7. Хорио цээрийн дэглэмийн үед орлого нь гэнэт тасалдсан иргэн, өрх;
- 2.1.8. Хорио цээрийн хязгаарлалтын улмаас хөл хорионд байгаа иргэн;
- 2.1.9. Орон гэргүй иргэн, харьяалалгүй этгээд;
- 2.1.10. Тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийн гэр бүл.
- 2.1.11. Хөл хорионд эцэг эх нь орсны улмаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд;
- 2.1.12. Холбогдох бусад.

2.2. Сум, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний нэгж нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд хүнс, тэжээлийн дэмжлэгт хамрагдах шаардлагатай зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхийн судалгааг энэ журмын 2.1-д заасан шалгуурыг үндэслэн гаргаж, аймаг, нийслэлийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлнэ.

2.3. Аймаг, нийслэлийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь энэ журмын 2.2-т заасан судалгааг нэгтгэж, нягтлан тодотгож Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.

2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь хүнс, тэжээлийн дэмжлэгт хамрагдах шаардлагатай зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхийн нэгдсэн судалгааг гаргаж Улс, аймаг, нийслэлийн Онцгой комисс, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагад мэдэгдэнэ.

Гурав. Зохион байгуулалт, мэдээлэл солилцоо

3.1. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх арга хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ажлын хэсгийг томилж, нэгдсэн удирдлагаар ханган аймаг, нийслэлийн Онцгой комисстой харилцан ажиллагаатай хамтран зохион байгуулна.

3.2. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх арга хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллага, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн байгууллага, Монголын улаан загалмай нийгэмлэг, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага хамтран зохион байгуулна.

3.3. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулалтын хувьд давхардуулахгүй.

3.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь хүнс, тэжээлийн дэмжлэгт хамрагдсан иргэн, өрхийн судалгааг аймаг, нийслэл, сум, дүүргээр улсын хэмжээнд нэгтгэж 7 хоног бүрийн Баасан гарагийн 16.00 цагт Улсын Онцгой комисс, Шуурхай штабт uok.shtab@nema.gov.mn цахим хаягаар хүргүүлнэ.

3.5. Аймаг, нийслэлийн Онцгой комисс нь хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх арга хэмжээг зохион байгуулах төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага, аж ахуйн нэгжид халдвараас сэргийлэх зөвлөмж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. Дэмжлэг үзүүлэх иргэн тухайн хүсэлтээ Монголын улаан загалмай нийгэмлэгт гаргаж болно.

3.6. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх арга хэмжээ зохион байгуулсан байгууллага, аж ахуйн нэгж нь санал, хүсэлтээ төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж болно.

3.7. Хүнс, тэжээлийн дэмжлэгт хамрагдах болон хамрагдсан иргэн холбогдох санал хүсэлтээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 261553, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 70147020, 70136987, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 108 дугаарын утсаар болон цахимаар гаргаж болно.

3.8. Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх арга хэмжээний зохион байгуулалтад шаардлагатай тохиолдолд цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдыг татан оролцуулж болно.

Дөрөв. Хүнс, тэжээлийг түгээх арга зам

4.1. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийг түгээхэд тухайн иргэн, өрхийн гэрээр хүргэх эсхүл урьдчилан тогтсон газарт тараах аргыг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэнэ.

4.2. Урьдчилан тогтсон газарт тараах аргыг хэрэглэх тохиолдолд дэмжлэг авах иргэний тоог хязгаарлах зорилгоор энэ журмын 2.2-т заасан судалгааг үндэслэн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нэг өрхийг төлөөлж, нэг хүн хүнсний тусламжийн багцыг авна.

4.3. Гэрээр түгээх аргыг хэрэглэх тохиолдолд тухайн иргэн, өрхөд түгээлт хийх цагийн хуваарь болон халдвараас сэргийлэх зөвлөмжийг дэмжлэгт хамрагдах иргэн, өрхөд урьдчилан утсаар мэдэгдэнэ. Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэхдээ тухайн эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхийн ам бүлийн тоог харгалзаж болно.

4.4. Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх арга хэмжээг тухайн зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхийг давхардуулахгүйгээр цагийн хуваарийн дагуу зохион байгуулна.

4.5. Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх арга хэмжээний аюулгүй байдлыг хангаж өдрийн цагаар зохион байгуулна.

Тав. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

5.1. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх арга хэмжээг зохион байгуулах хүсэлтэй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хүсэлтээ тухайн орон нутгийн Нийгмийн халамжийн байгууллагад, нийслэлд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт гаргана. Ирүүлсэн хүсэлтийг энэ журмын 3.1-д заасан ажлын хэсэгт хүргүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтийг зохион байгуулна.

5.2. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд үзүүлэх хүнс, тэжээл нь гарал үүсэл тодорхой, шинжилгээ баталгаажилтад хамрагдсан, хадгалалтын хугацаа хэтрээгүй, эрүүл мэндийг дэмжсэн шим тэжээллэг байна.

5.3. Дэмжлэг тусламжаар өгөх хүнс, тэжээлийг зориулалтын агуулахад хадгалалтын горимын дагуу хадгална.

5.4. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд түгээх хүнс, тэжээлийг цуглуулах, савлах, багцлах бэлтгэх байр /цаашид "бэлтгэх байр" гэх/-нд тухай бүр, харин тээврийн хэрэгсэлд түгээлтийн өмнө болон дараа халдваргүйжүүлэлт хийнэ.

5.5. Дэмжлэг үзүүлэх хүнс, тэжээлийг тээвэрлэх, зөөвөрлөх, түгээхэд хялбар байх, нэг хүн өргөж авч явахад тохиромжтой байхаар савлаж, багцалж бэлтгэнэ. Шаардлагатай тохиолдолд хэрэглээний бараа бүтээгдэхүүн /ариун цэврийн хэрэглэл, ОО цаас, живх, гарын саван, гар утасны нэгж г.м/ болон халдвараас сэргийлэх хэрэглэл /амны хаалт, нэг удаагийн бээлий, гар халдваргүйжүүлэх бодис г.м/-ийг багцад нэмэлтээр оруулж болно.

5.6. Бэлтгэх байранд ажиллах хүний халдвар хамгааллын дэглэм сахиулахад шаардлагатай хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, маск, бээлий, малгай, нүүрний хаалт, нүдний шил, гутлын улавч г.м), халдваргүйжүүлэх бодисын нөөцийг бүрдүүлнэ.

5.7. Бэлтгэх байранд ажиллах хүний биеийн халууныг тухай бүр хэмжиж тэмдэглэл хөтөлнө. Халдварын сэжигтэй шинж тэмдэг /37.1 хэмээс дээш халуурах, ханиалгах, амьсгаадах/ илэрсэн үед эрүүл мэндийн байгууллагад нэн даруй мэдээлж, хорио цээрийн дэглэмийг чанд сахина.

5.8. Бэлтгэх байранд хүн хооронд 1.5 метр зай барьж, тасалгааны агаар сэлгэлт, цэвэрлэгээг 2 цаг тутамд хийж, гар халдваргүйжүүлэх бодисыг байрлуулж, ажиллах нөхцөл бүрдүүлнэ.

5.9. Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх үйл ажиллагаанд гардан оролцох ажилтан, сайн дурын идэвхтэнд халдвар хамгааллын заавар зөвлөмжийг урьдчилж өгнө.

5.10. Хүнс, тэжээл түгээх тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, тээврийн хэрэгслийн бүхээгт жолооч, ажилтны хувийн ариун цэврийг сахих, халдвараас сэргийлэх зөвлөмжийг байрлуулж, мэдээллээр хангана.

5.11. Хүнс, тэжээл түгээх үйл ажиллагаанд оролцогчийн аюулгүй байдлыг сахиулж, амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэх бодис, хогны уут зэргээр хангана.

5.12. Түгээлтийн үйл ажиллагаанд оролцох ажилтан, сайн дурын идэвхтнийг Ковид-19 халдварын шинжилгээнд нэгдсэн журмаар хамруулах ажлыг зохион байгуулна.

5.13. Тусламж дэмжлэгийн хүнс, тэжээл түгээх чиглэл, цагийн хуваарийг аймаг, нийслэлийн онцгой комисст тухай бүр мэдэгдэж, зөвшөөрөгдсөн бүсэд үйл ажиллагааг зохион байгуулна.

5.14. Хүнс, тэжээлийн түгээлтийг халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, хүн хоорондын зай барьж, бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохион байгуулна.

5.15. Бэлтгэх байрнаас хүнс, тэжээлийг тухайн өдөрт түгээх тоо хэмжээгээр тээврийн хэрэгсэлд ачина. Түгээлтээс илүү гарах тохиолдолд бэлтгэх байранд бусад хүнс, тэжээлээс тусад нь хадгална.

Зургаа. Хүнс, тэжээл түгээлтийн үйл ажиллагаанд оролцогч ажилтны үүрэг

6.1. Хүнс, тэжээл түгээлтийн үйл ажиллагаанд оролцогч ажилтан нь түгээлтийн явцад халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, амны хаалт, нэг удаагийн бээлий хэрэглэнэ. Мэргэжлийн байгууллагаас зөвлөсөн тохиолдолд хувийн хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэнэ.

6.2. Хүнс, тэжээлийн дэмжлэгт хамрагдах иргэнтэй биеэр хүрэлцэхгүй зайнаас харилцана. Тухайн иргэнд амны хаалт, бээлийтэй байх шаардлага тавина.

6.3. Хүнс, тэжээлийн дэмжлэгийг гэрээр түгээж байгаа тохиолдолд тухайн багцыг гэр, /хашаа/-ийн гадна үлдээж, утсаар гарч ирж авахыг мэдэгдэж, дэмжлэг үзүүлсэн талаар зайнаас зураг авч баталгаажуулна.

6.4. Түгээлтийн дараа хэрэглэсэн хамгаалах хувцас, амны хаалт, нэг удаагийн бээлий, бусад хог хаягдлыг битүүмжлэн, зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяна.

6.5. Тээврийн хэрэгсэлд суух, буух бүрт гар халдваргүйжүүлэгч хэрэглэнэ.

6.6. Хүнс, тэжээл түгээлтийн үйл ажиллагаанд оролцогч ажилтан тухайн айл, өрхийн гэрт орох, бэлэг авахыг хориглоно.

Долоо. Хяналт

7.1. Энэ журамд заасан халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээний хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

7.2. Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх үйл ажиллагаанд Цагдаагийн байгууллага хэв журам сахиулж, дэмжлэг үзүүлнэ.

Найм. Бусад

8.1. Түр журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол, шийдвэр, заавар, дүрэм, журам зэрэгт нийцсэн байна.

8.2. Энэхүү түр журмыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулах, цуцлах хүртэлх хугацаанд мөрдөнө.

8.3. Энэхүү түр журмыг дагаж мөрдөөгүй иргэн, хуулийн этгээдийг болон хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.